



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 04 өдөр

Дугаар 4/536

Есөнбулаг

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 11 дүгээр тогтоол, 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 78 дугаар тогтоол, 2024 оны 40 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.1 дэх заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2024 оны элсэлтийн ерөнхий шалгалт, улсын төрөлжсөн олимпиадад амжилт үзүүлсэн багш нарт хүндэтгэл үзүүлэх "Багш-Эрдэнэ" арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Ш.Насан	(Аймгийн Засаг даргын нийгмийн бодлого хариуцсан орлогч)
Гишүүд:	Х.Баатарзориг	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, Төрийн сангийн хэлтсийн дарга)
	Д.Энхцэцэг	(Аймгийн боловсролын газрын дарга)
	Э.Отгонбаатар	(Ардын дуу бүжгийн Алтай чуулгын дарга)
	Н.Байгальмаа	(Аймгийн Боловсролын газрын ахлах мэргэжилтэн)
	Б.Амартүвшин	(Аймгийн Боловсролын газрын мэргэжилтэн)
Нарийн бичгийн дарга:	А.Алтанхуяг	(Есөнбулаг сумын Засаг дарга)
	С.Мөнхжаргал	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)
	Ж.Амгаланбаатар	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт, шинжилгээ-үнэлгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

2. Захирамжийн хэрэгжилтийг хангаж, арга хэмжээг чанартай зохион байгуулахыг ажлын хэсэг (Ш.Насан)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Ж.Амгаланбаатар)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ЧИНБАТ